



9
2.

**УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ**

1963-I-17.

дугаар 2.

Улаанбаатар хот

13-нөм 1990 оны 140 р тогтоомжийг бүтээгч

Улаанбаатар хотын түүх, шинэчлэн
байгуулалтын музейн дүрмийг
батлах тухай.

Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ нь.

~~1. Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музейн
дүрмийг баталсугай. / дүрмийг хавсаргав /~~

~~2. Энэ дүрмийг музейн ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахыг
музейн эрхлэгч н. Дүрзээд даалгасугай.~~



УЛААНБААТАР ХОТЫН АДХ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА *Лувсанчоймбол* ЛУВСАНЧОЙМБОЛ
ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА *Донров* ДОНРОВ

зөвшөөрсөн.....
боловсруулсан.....
нийлсэн... *Лувсанчоймбол* ...
6% цо. Загджав.

Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн 1963 оны I-р сарын 17-ны эдрийн 2-р тогтоолоор батлав.

Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музейн дотоод дүрэм.

НЭГ. ЗОРИЛГО БА ЧИГЛЭЛ

1. Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей нь эх орноосоо нийслэлийн түүхт замнал, социалист өөрчлөлт хөгжилт ба ирээдүйн төлөвийг өөрийн орно хөдөлмөрчид болон гадаадын хүмүүст сурталчлах, нийслэлийнхээ түүх-соёлын ов дурсгалыг арвижуулан хамгаалах зорилгоор байгуулагдсан түүх судлал-эрдэм шинжилгээний чухал бааз мөн.

2. Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музейн бүх ажиллагаа нь хөдөлмөрчдийг эх оронч, интернационалист үзэл, коммунист хүмүүжлээр хүмүүжүүлэхэд чиглэгднэ.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3. Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музейг улсаас баталсан төсөв, орон тоотойгоор Улаанбаатар хотын А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны соёлын хэлтсийн харьяанд байгуулж ажиллуулна.

4. Музейн эрхлэгчийг Улаанбаатар хотын АДХ Захиргааны даргын тушаалаар тайлбарлагч, фондч, кандидатиг соёлын хэлтсийн даргын тушаалаар бусад үйлчлэх ажилчдыг музейн эрхлэгчийн тушаалаар тус тус томилж ба өөрчилнө.

5. Музейд байгаа түүх-соёлын дурсгалт зүйлс, эд өлгий нь батлагдсан маягтуудаар үзэн зөв бүртгэгдсэн байх бөгөөд үзэмрийн зүйлс нь нийтийн үзэж сонирхоход зориулагдана. Үзэмэрт тавигдаагүй зүйлс нь фондын дүрэм ёсоор хадгалагдан ашиглагдана.

ГУРАВ. АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЖУРАМ

6. Музейн захиргаа, төвлөн удирдах зарчмын үндсэн дээр музейн эрдэм шинжилгээний зөвлөл ба идэвхтнүүдийн хүчин туслалцааг түшиглэн дор дурдсан үндсэн хэлбэрүүдээр ажлаа явуулна. Үүнд:

а/ Баталсан цагийн хувиараар хөдөлмөрчдөд музей үзүүлэх ажлыг өргөнөөр зохион явуулах.

б/Музей үзэгчдийн зөвлөлгөөн лекц, яриа хийх, уулзалт удашлал зохиох, хэвлэл радиогоор сурталчлах, зурагт хуудас, танилцуулга гаргах зэргээр нийслэлийн түүхт замнал, ололт амжилтуудыг тайлбарлаж таниулах ажлыг өргөн явуулах.

в/Түүх соёлын дурсгалт зүйлсийг хайрлаж хамгаалах, олж сурвалжлах ажлыг хөдөлмөрчдийн дунд байнга зохион музейн үзмэр, фондын зүйлсийг тасралтгүй баяжуулан аривжуулах.

7.Музейн бүх ажлыг түүх-судлал, эрдэм шинжилгээний үндэслэлтэйгээр удирдаж явуулах зорилгоор музейн дэргэд 10-15 хүний бүрэлдэхүүнтэй эрдэм шинжилгээний зөвлөл байгуулж ажиллуулна.

8.Музейн эрдэм шинжилгээний зөвлөлийг Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хурлаар батлах, ба өөрчилнө.

9.Музейн эрдэм шинжилгээний 3 зөвлөлөөс дор дурдсан үндсэн эрх үүрэгтэйгээр ажиллана. Үүнд:

а/Музейн жилийн ба улиралын ажлын төлөвлөгөө, тайланг эрдэм шинжилгээний талаас нь хэлэлцэж батлана.

б/Музейг өөрчлөн байгуулах, эрдэм шинжилгээний ажлыг тал бүрээс нь судлан дүгнэх, музейн ажлыг сайжруулах практик арга хэмжээг авч явуулна.

в/Музейн эрдэм шинжилгээний зөвлөл нь музейн захиргаанд зөвлөх эрхтэйгээр хамтын удирдлагын хэлбэрээр ажлаа явуулах бөгөөд зөвлөлийг музейн эрхлэгч даргална.

**ДӨРӨВ. МУЗЕЙН АЖИЛТАН, АЖИЛЧДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

10.Музейн бүх ажлыг хотын захиргааны соёлын хэлтсийн өмнө музейн эрхлэгч хариуцна. Музейн эрхлэгчийн үүрэг нь:

а/Музейн ажилтан, ажилчдыг удирдан зохион байгуулж тэдний ажилд хяналт тавих замаар музейн дүрмийг хэрэгжүүлэн биелүүлэх.

б/Музейн үзмэр ба фондын зүйл, эд аж ахуй, санхүүд хяналтыг тавьж тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангах.

в/Музейн фонд ба үзмэрийг байнга өргөтгөн баяжуулж, хөдөл-

3.

мөрчдөд нийслэлийн түүхт замналыг олон хэлбэрээр сурталчлах. музей үзэгчдийн тоог олшруулан үйлчилгээг сайжруулах.

г/Музейд соёлч боловсон байдлыг нэвтрүүлэх. музейн эрхлэгчийн врх нь.

а/Музейн хэвийн ажиллагааг хангах, музейн ажлыг сайжруулахад чигжүүлэн тушаал гаргах, комисс томилох зэрэг бусад арга хэмжээнүүдийг музейн хэмжээн дээр авч явуулах.

б/Үйлчлэх ажилчдыг ажилд авах ба өөрчлөх, сахилга батын арга хэмжээ авах.

в/Музейн үзэмрийн зохион байгуулалтанд жижиг өөрчлөлтүүд хийх.

II.Музейн бүх ажилтан, ажилчид, ажлынхаа талаар музейн эрхлэгчийн эмгэ шууд хариуцаж, оногдсон үүргээ шудрагаар биелүүлэх үүрэгтэй. Үүнд:

а/Музейн тайлбарлагч нь музейн үзмэрт тавигдсан бүх зүйлийг нэвтэрхий сайнаар судлан мэдэж үзэгчдэд үнэн зөв тайлбарлаж хөдөлмөрчдөд хөнгөн гавшгай үйлчлэхийн хамтаар хотын хүүхт хөгжлийг олон хэлбэрээр сурталчлах үүрэгтэй.

б/Музейн фондоч нь музейн фондын дүрэм ёсоор ажиллан зохих үүрэг хариуцлагыг гүйцэтгэх үүрэгтэй.

в/Музейн каминдат ба бусад үйлчлэх ажилчид нь музейн хэвийн ажиллагааг явуулахад шаардагдах нөхцлийг хангах, хөдөлмөрчдөд хөнгөн шуурхай үйлчлэх, музейн дотоод ариун цэвэр, боловсон байдлыг үлгэр шинэ жишээч байлгах гол үүргийг гүйцэтгэнэ.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

12.Музей нь"Улаанбаатар хотын түүх-шинэчлэн байгуулалтын музей" гэсэн үсэг бүхий тэмдэг ба нүүртэй байна.

13.Музейн дэргэд үлгэрийн танхим тогтоосон журмаар ажиллана.

14.Музейн үзмэр ба фондын зүйлийн тооллого тооцоог жил дутам явуулж байна.Музейн эрхлэгч ба фондоч солигдоход үзмэр ба

4.

Фондын зүйлийн тооллогыг явуулж хүлээлцэнэ.

15.Музейд түүх соёлын дурсгалт зүйлийг цугларуулах ба түүхийн дурсгалт зүйлийг хамгаалах,уг ажилд идэвхтэй оролцог-содыг урамшуулан шагнах явдлыг тусгай батлагдсан заавраар гүйцэтгэнэ.

16.Музейн дүрмийг Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хурлаар батлах ба өөрчилнө.

УЛААНБААТАР ХОТ.

НИЙЛСЭН.....
ХЯНАСАН.....
6% цо. Загджав.